



“АДХИМИ СЕЛИС КЛЕН ФЕРПЕКТ” ХХК

Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлах  
“АДХИМИ СЕЛИС КЛЕН ФЕРПЕКТ” ХХК-ийн ХИМИЙН  
БОДИС ИМПОРТЛОХ, ХУДАЛДААЛАХ АГУУЛАХЫН  
ТӨСӨЛ

2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Хянасан:

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв  
байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын мэргэжилтэн

Боловсруулсан: Адхими Селис Клен Ферпект ХХК-ийн ахлах  
эрүүл ахуйч: О.Уранчимэг

Баталсан: Адхими Селис Клен Ферпект ХХК-ийн Ерөнхий  
захирал: С.Гэрэл



## **АГУУЛГА**

### **БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

- 1.1 Төслийн товч мэдээлэл
- 1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн товч танилцуулга
- 1.3 Төслийн зорилго
- 1.4 Төслийн зорилт

### **БҮЛЭГ 2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

- 2.2 Менежментийн төлөвлөгөөний зорилго
- 2.3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- 2.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
- 2.4 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- 2.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- 2.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

ТӨСЛИЙН НЭР	“ЦЭВЭРЛЭГЭЭ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХУДАЛДААЛАХ, ХАДГАЛАХ ”
ТӨСЛИЙН ЗОРИЛГО	Олон улсын чанарын шаардлагад нийцсэн, салбартаа тэргүүлэгч дэлхийн брэндийн бүтээгдэхүүнүүдийг импортлон хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчим хүчний салбарт хэрэглэгдэх чанартай бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах.
ТӨСЛИЙН БАЙРШИЛ	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Интердесижн ХХК-ийн агуулах
ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бүтээгдэхүүн импорлох, худалдах, сургалт мэдээлэл зөвлөгөө өгөх.
ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮР ДҮН	Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт эрүүл ахуйн чанар стандартыг олон улсын жишигт хүргэхэд өөрийн тус нэмрийг оруулах, уул уурхай, цахилгаан дулааны станцуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай бодис бүтээгдэхүүн нийлүүлэн хамтран ажиллах
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:	<b>“Адхими Селис Клен Ферпект” ХХК</b>
ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА:	2025 он

## 1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай байгууллага 2004 оноос хойш АНУ-ын “ECOLAB” компанийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн 100 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, үйлчилгээ, эрүүл мэнд, уул уурхай, цахилгаан станцууд зэрэг чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 1000 орчим байгууллага, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэн, сургалт мэдээлэл өгөн хамтран ажиллаж байна. Манай байгууллагын эрхэм зорилго нь Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эмнэлэг, үйлчилгээний байгууллагууд, хүнсний үйдвэрүүд, сургууль цэцэрлэг, уул уурхайн компаниуд зэрэг газруудад шаардлагатай цэвэрлэгээ, ариутгалын бэлдмэлийг ханган нийлүүлэх, эрүүл ахуй, халдвар хамгааллын талаар сургалт зохион байгуулах, олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг юм.

Одоогоор манай компани олонхи хүнсний үйлдвэрүүд эмнэлэг, сургууль, цэцэрлэг, банк, ресторан, бассейн, саун, бар, зочид буудал, хими цэвэрлэгээний зэрэг газрууд, хувь хүмүүстэй тогтмол харилцаатай ажиллаж байна.

### **Манай компани Монгол улсын хуулийн хүрээнд:**

- "Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам"-ны "Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, худалдах тусгай зөвшөөрөл"-тэй
- "Эрүүл Мэндийн Яам"-ны "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл"-тэй
- "Эрүүл Мэндийн Яам", "Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам", "Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам"-ны сайд нарын хамтарсан “Монгол улсад тухайн онд ашиглаж болох ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалт”-нд манай компанийн импортлодог халдваргүйжүүлэлтийн бэлдмэлүүд багтсан.

Монгол улсын хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх гол хүчин зүйл болох эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, Олон улсын HACCP, GMP, GHP, ISO 9001, ISO 14001 стандартуудыг нэвтрүүлэхэд шаардлагатай зөв дадал хэвшил, хяналтыг бий болгох, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар зөв мэдлэг мэдээллээр хэрэглэгчдийг хангах зэрэгт анхаарч холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай сургалт зохион байгуулан хамтран ажиллаж байна.

## 1.3 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 сарын 24-ний өдрийн А/406 тоот “ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД МӨРДӨХ ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ” тушаалаар батлагдсан хүнсний үйлдвэр болон үйлчилгээний газрын орчны халдвар хамгаалал, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ халдваргүйтгэл, ажилчдын гар ариутгал, хувцас хэрэглэл ариутгал нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд “ECOLAB” компанийн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэлүүд, дэлхийн стандартад нийцсэн бодис бүтээгдэхүүнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө багатай бодис бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулан ажиллах зорилго тавин ажиллана.

## 1.4 ТӨСЛИЙН ЗОРИЛТ

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор нөлөө багатай бэлдмэл импортлох, борлуулах

- Бүтээгдэхүүний хэрэглээ болон аюулгүй ажиллагааны талаарх сургалт зохион байгуулах
- Дэлхийд шинээр нэвтэрч буй техник технологи, бэлдмэлийг судлах, турших, мэдээллэх, нэвтрүүлэх
- Олон улсын болон Монгол улсын эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагуудтай нарийн нягт уялдаа холбоотой ажиллах, хууль дүрмийг биелүүлэх.

Дээрх зорилтын хүрээнд бид шинэлэг, хүртээмжтэй, хүн амын эрүүл мэнд, хүнсний болон эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай үйл ажиллагааг өргөжүүлэх, мэдлэг мэдээллээр олон нийтийг хангахад холбогдох төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах болно.

## БҮЛЭГ 2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 2.1 Менежментийн төлөвлөгөөний зорилго

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/168 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болгосон.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах;
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх;
- Компанийн ажилтнууд, хорооны иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

## 2.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	
1	Агаарын чанар	Агуулахад хадгалагдаж буй химийн бодист байнгын хяналт тавих, агуулах орчмын агаарын чанар муудсан шинж тэмдэг илэрвэл тухай бүрд нэн даруй мэргэжлийн байгууллагад хандаж шаардлагатай арга хэмжээг авах	Төслийн талбайд	тогтмол	-	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS: 4585:2016 Авто тээврийн тухай хууль, Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS: 4589:2011
2	Усан орчин бохирдох Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл	Хурын усыг хуримтлуулж, хуурайшилттай үед зам талбайг услах, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах	Усны нөөц, зохистой хэрэглээ	тогтмол	-	-	Үйл ажиллагааны зардал	2025	Усны тухай хууль Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам

		Ус хэмнэлттэй ашиглах зөвлөмж							
3	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд элдэв төрлийн бодис /тээврийн хэрэгслээс тос, тослох материал, ахуйн хэрэглээнээс гарах хатуу, шингэн хаягдал/ алдахгүй байх, ажилчдад орчны бохирдлын талаар зөвлөмж мэдээлэл өгөх	Төслийн нийт албан хаагчид	Тогтмол	-	-	Үйл ажиллагааны зардал	2025	Хөрс хамгаалах тухай хууль
	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төсөл хэрэгжиж буй дүүрэг хорооны удирдлагаас санал авч мод тарих	Хөрс, ургамал, агаар орчин	Ширхэг	25,000	50	1,250,000	2025	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн MNS 5914:2008 Байгаль орчин эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх	Төслийн үйл ажиллагаанаас эвдэрсэн	Төслийн талбай	Төслийн талбайд	-	га	Үйл ажиллагааны зардал	2025	MNS 5850:2019 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч

сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	хөрсийг нөхөн сэргээх							бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт						1,250,000		

### ХИМИЙН БОДИС АЛДАГДСАН ТОХИОЛДОЛД ХЭРЭГЛЭХ ХАМГААЛАХ ИЖ БҮРДЭЛ






**ХИМИЙН БОДИС АЛДАГДСАН ТОХИОЛДОЛД  
ХЭРЭГЛЭХ ХАМГААЛАХ ИЖ БҮРДЭЛ**



# БОЛЗОШГҮЙ ОСЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

## ПРОЦЕССИЙН ДИАГРАММ



Химийн бодисын агуулахад ба хэмжээгээр бодис алдагдсан үед ашиглахад хэрэглэх иж бүрэн хамгаалах хувцас хэрэгслийг байрлуулсан ба болзошгүй ослын үеийн төлөвлөгөөг бэлтгэсэн.


### 2.3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ногоон байгууламж бий болгох	Хайлаас, шар хуайс, улиас	Төслийн талбайд болон “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, арчилгааг хариуцах	ширхэг	25,000	50	1,250,000	2025 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
2	Хөрс бэлтгэх Нүх бэлтгэх	Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ	Ажилчны хөлс	Ажилчин	-	2	500,000	2025 он	Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260:2020
	Нийт						1,750,000		

Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн хүрээнд шар хуайс, монгол хайлаас, бургас зэрэг мод бутыг тариалах тохиромжтой хугацаанд буюу хавар 4-р сарын сүүл, 5-р сарын эхээр, намар 9-р сарын сүүл 10-р сарын эхээр тариалах хугацаанд 1-2 настай суулгацыг сонгон авч төлөвлөсний дагуу тоо ширхэгээр тарина. Өмнөх оны төлөвлөгөөнд 30 ширхэг тарихаар төлөвлөсөн ба энэ онд ч мөн ижил тоогоор тариална. Мод тарих, арчлах дарааллыг зурагт заасны дагуу гүйцэтгэнэ. Өмнөх онуудад тариалсан мод бутны ургалт 60%-тай.

**1**

**Суулгацын нүх ухах**



Гүн 70 см  
Диаметр 100 см

**2**

**Хөрс бэлтгэх**



50% - хар шороо  
30% - эмс, 20% - хөвс бууц  
бусад бэрлээг хийнэ.

**3**

**Суулгацыг тарих**



Суулгацыг тарихдаа нүхний голд унасныг нугалахгүйгээр жинг тарааж суулгана.

**4**

**Услах арга**



Суулгасны дараагаар хөрсний сайтар нөвтрүүлж гөвгөж өгөх, нэг модыг 60-80л усгаар услана.

**5**

**Тариатын дараах арчлагаа**



Өглөө, оройн цагаар 7-10 хоногт 40-50л усгаар нэг модыг 1-2 удаа усална. 10 сара цэнэг усалгааг хамтал хийнэ. Усалгаа хийх явцад хөрсний нойруулалт хийнэ.

**6**

**Байгальд дасан зохицон ургах**



3 жилийн дараагаас арчлагаа усалгааг хийх шаардлагагүй болно.

## 2.4 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологи, палеонтологийн дурсгал	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төсөл хэрэгжүүлэх нийт талбайн хэмжээнд	-	Тухайн үед нь шийдэх	Тухайн үед нь шийдэх	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/, Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд
		Нийт						

## 2.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгах цэгийг тохижуулах	Хог хаягдлын цэг	Иж бүрэн  Тогтмол	1,000,000	1 удаа	1,000,000	2025 он	Хог хаягдлын тухай хууль БОАЖ-ын сайдын А/433 тогтоол

		<p>Эзэмшил газрын ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж цэвэрлэж байх</p> <p>Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид шилжүүлэх</p> <p>Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлт ийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх</p> <p>Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх</p>	<p>Ойр орчмын 100 метрт</p> <p>Дахин ашиглагдах хог хаягдал</p> <p>Хог хаягдлын цэгт</p> <p>Агуулахын ажилчдад</p>	<p>Тогтмол</p> <p>Тогтмол</p> <p>удаа</p>	50,000	<p>Үйл ажиллагааны зардал</p> <p>Үйл ажиллагааны зардал</p> <p>Улиралд 1 удаа</p> <p>Үйл ажиллагааны зардалд тусгагдсан</p>	50,000		
2	Аюултай	<p>Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх</p> <p>Химийн бодисын сав баглаа боодол асгарсан үед</p>	<p>Төслөөс үүсэх аюултай хог хаягдал</p>	Тогтмол	Гэрээний дүнгээр	<p>Үйл ажиллагааны зардалд тусгагдсан</p>	2025 он	<p>Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 116 тогтоол</p> <p>Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин</p>	

		арчсан даавууг устгахдаа эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан устгуулах / Адхими Селис Клен Ферпект ХХК, Элемент ХХК-ийн хооронд 2024.09.10-ны өдөр байгуулсан Химийн хортой болон аюултай бодисын хаягдал, тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх № ХБ-24/136 тоот гэрээний дагуу аюултай хог хаягдлын устгал хийлгэдэг/						боловсруулах , устгах болон бүртгэх журам	
		Нийт				1,050,000			

Өдөр тутамд агуулахаас гарах ахуйн хог хаягдал бага тул түрээслэгч байгууллагын төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг хаях ба хэрэглэгчээс хэрэглэж дууссан химийн бодисын хоосон хуванцар савыг эргүүлэн татан төвлөрүүлж Налайх дүүрэг, 3-р хороо, Бүс нуур хаягт байрлах Элемент ХХК-ийн аюултай хог хаягдал устгалын үйлдвэрт устгуулан аюултай хог хаягдал устгасан тухай акт үйлддэг.

## 2.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
	Төслийн талбайд ил гал гаргаж	Төслийн талбайд	Тухайн бүсэд	120,000	1	120,000	Үйл ажиллагааны туршид	MNS: 5002:2000 “ХААЭА, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага”

	болохгүйг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах							
2	Химийн бодис алдагдах, асгарах тохиолдолд /Хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, метал юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг/ авч байршуулна	Ажилчдад	Иж бүрэн	-	1	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2025 он	MNS ISO 13688:2000 “ХААЭА Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”
3	Агуулахад гал түймрийн үед хэрэглэх галын хор, сараа байршуулах	Ажилчдад	Иж бүрэн	-	1	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2025 он	MNS: 5390:2004 “ХААЭА Цахилгааны галын аюулгүй байдал Ерөнхий шаардлага”
4	Агуулахад термометр байршуулах	Агуулахад	ширхэг	-	1	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2025 он	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
5	Ажилчдыг ХАБЭА сургалтанд хамруулж дадлагажуулах	Төслийн талбай Ажилчдад	Улирал тутамд	100,000	-	100,000	2025 он	MNS: 6458:2014 Химийн бодисын агуулах, хадгалах орчны аяналт аюулгүй байдлыг ханга, химийн



								бодисын агуулахад тавигдах шаардлага
6	Ажиллагсдыг зориулалтын иж бүрэн хувцас хэрэгслээр хангах	Ажилчдад	Иж бүрэн	-	Нийт ажилчид	Үйл ажиллагааны хүрээнд	2025 он	
7	Ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг шинжилгээнд хамруулах	Ажилчдад	Жилд 1 удаа	-	Нийт ажилчид	Гэрээт ажлын дүнгээр	2025 он	
	Нийт					220,000		

Жил бүр ажилчдыг байгууллагаас зохион байгуулдаг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг ба 2025 оны 2-3 улиралд үзлэгийг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.